

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/01

Улаанбаатар хот

Дотоод аудитын дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2021 оны 2 сарын 05-ны өдрийн хурлаас гарсан дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дотоод аудитын дүрмийг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн Дотоод аудитын дүрэм шинэчлэгдэн батлагдсантай холбоотой ТУЗ-ийн 2018 оны 10 сарын 24-ний өдрийн 18/23 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Дотоод аудитын дүрмийг мөрдөж ажиллахыг Компанийн дотоод аудитор /М.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
4. Дотоод аудитын дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/02

Улаанбаатар хот

Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлого батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2021 оны 2 сарын 05-ны өдрийн хурлаас гарсан дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлогыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлогыг хэрэгжүүлж ажиллах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-т даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/03

Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны санхүүгийн болон
үйл ажиллагааны тайлангийн
талаар дүгнэлт батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлаас гарсан дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК аудит хийж, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг ТУЗ-ийн Дарга /Ц.Одмаа/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/04

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын 2020 оны ажлын гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дугаар зүйлийн 81.5.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9.6.9 дэх заалт, Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн контракт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2021 оны 2 сарын 05-ны өдрийн дүгнэлт, санал, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатарын 2020 оны ажлын гүйцэтгэл, түүний үр дүнг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар, түүнд олгох 2020 оны үр дүнгийн урамшууллыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Компанийн Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 1 сарын 29-ний өдрийн өдрийн 28 тоот тогтоол, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 0.58 (тэг зууны тавин найм) төгрөгөөр тогтоож, Компанийн 2020 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 20 (хорь) хувийг буюу 447,843,214.92 (дөрвөн зуун дөчин долоон сая найман зуун дөчин гурван мянга хоёр зуун арван дөрөв зууны ерэн хоёр) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 2 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2021 оны 4 сарын 30-ны өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашигийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгож ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/06

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ГУЗ”)-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/07

Улаанбаатар хот

**Компанийн бүтцийг шинэчлэн
батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.10 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2019 оны 8 сарын 26-ны өдрийн 19/45 тоот Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Компанийн шинэчлэгдэн батлагдсан бүтцийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, алба, хэлтэс, нэгжийн албан тушаалтныг чиг үүргээр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.
4. Компанийн үйл ажиллагаатай уялдуулан, зарим хэлтэс, алба нэгжийн зохион байгуулалт, чиг үүрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд хэлтэс, алба нэгжийн нэршил болон харьяаллыг өөрчлөх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д олгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/08

Улаанбаатар хот

Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн Дүрмийн 9.6.4 дахь заалт, Компанийн Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын 6 дугаар зүйлийн 6.8, 6.12 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлаас гарсан дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, бусад арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнээс давсан, эсхүл хоёрдогч эх үүсвэрийн санал, Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу Компанийн ТУЗ-өөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.
4. Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Ц.ОДМАА

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/09

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх
эрхийг олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 болон 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бүүминг Трейд” ХХК-тай зээл болон барьцааны гэрээ байгуулж, зээл олгох эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д олгосугай.
2. “Бүүминг Трейд” ХХК-тай байгуулах зээлийн үндсэн нөхцөл болон хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд “Бүүминг Трейд” ХХК-тай гэрээний нөхцөлийг харилцан тохирч байгуулах, гэрээний хэрэгжилтийн талаар ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

[Signature] /Ц.ОДМАА/

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

[Signature] /О.БОЛДБААТАР/

[Signature] /В.БАЯРСАЙХАН/

[Signature] /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

[Signature] /С.БОРГИЛ/

[Signature] /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

[Signature] /Н.ЦЭВЭГМИД/

[Signature] /С.ЭНХ-АМГАЛАН/

[Signature] /Б.ӨЛЗИЙБАЯР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/10

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 2 дугаар бүлгийн 2.1, 2.3, 2.5 дахь хэсэг, 3 дугаар бүлэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 238 тоот тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 1 сарын 22-ны өдрийн А/25 тоот захирамж, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 болон 8.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хурлыг 2021 оны 3 сарын 20-ны өдрийн 12:00 цагт цахим хэлбэрээр буюу хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүй байдлаар зохион байгуулж, Компанийн Фэйсбүүк хуудсыг ашиглан хувьцаа эзэмшигчдэд шууд дамжуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - 2.1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ГУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.3. Компанийн ГУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 2.4. Компанийн ГУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох;
 - 2.5. Компанийн ГУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох;
 - 2.6. Компанийн ГУЗ-ийн 2021 оны төсвийг батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 02 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтын дагуу баталж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д 2021 оны 2 сарын 08 -ны өдрийн дотор хүргүүлэхийг ГУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хоёрдугаар хавсралтын дагуу баталж, 2021 оны 2 сарын 10 болон 25-ны өдрүүдэд Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевиз болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Гуравдугаар Хавсралтын дагуу баталж, баримт бичгийг 2021 оны 2 сарын 10-ны өдрийн дотор бэлтгэн, 2021 оны 2 сарын 15-ний өдрийн дотор хувьцаа

эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Гуравдугаар хавсралтад заасан баримт бичгийг 2021 оны 2 сарын 08-ны өдрөөс эхлэн 2021 оны 3 сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд Компанийн www.Lend.mn вэбсайтруу хандаж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг Компанийн ажилтнуудаас дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

М.Түвшинжаргал

Санхүү, үйл ажиллагааны газрын захирал

Гишүүд:

Б.Удвал

Дэд захирал

М.Бямбасүрэн

Эрсдэл, Хянан нийцүүлэлтийн газрын захирал

Б.Пүрэвсүрэн

Маркетингийн албаны менежер

Т.Од

Мэдээлэл технологи хариуцсан захирал

О.Энэрэл

Маркетингийн менежер

Б.Батбилэг

Маркетингийн менежер

О.Батзаяа

Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн менежер

Э.Эрэлхэгзориг

Мэдээллийн технологийн ахлах инженер

П.Одмаа

Төслийн менежер

Э.Насанжаргал

Систем хөгжүүлэлтийн менежер

Ж.Мөнхцэцэг

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

С.Батбуян

“ЭмДиЭс Хаан Лекс” ХХН, Партнер

Гишүүд:

Б.Оюунболд

Хуулийн зөвлөх

М.Номин

Санхүүгийн шинжээч

М.Оюун-Эрдэнэ

Дотоод аудитор

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудасны дагуу санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын дарга /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Дөрөвдүгээр хавсралтын, санал авах хуудсыг Тавдугаар хавсралтын “а”, “б”, “в” хэсгийн дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд тараах замаар Хувьцаа эзэмшигчдийн хурлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн

авах эцсийн хугацааг 2021 оны 3 сарын 19-ний өдрийн 18:00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.

14. Компанийн энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулах саналыг 2021 оны 2 сарын 28-ны өдрийг хүртэл хүлээн авахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/, Хурал зохион байгуулах комиссын дарга /М.Түвшинжаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.
15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ж.Мөнхцэцэг/, Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар / нарт тус тус үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 2 сарын 05-ны өдөр

№ 21/11

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захиралд зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Дүрмийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2 сарын 05-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-ыг “Ай Эн Мобайл Нэтворк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд гишүүнээр орж давхар ажиллахыг зөвшөөрсүгэй.

